



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/69

Бат-Өлзий сум


Газар ашиглуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хужирт-Бат-Өлзий чиглэлийн хатуу хучилттай 49 км авто зам, замын байгууламжийн ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан "Мотор сервис" хязгаарлагдмал хариуцлагатай компанид замын барилга байгууламжийг гүйцэтгэх хугацаанд кемпийн зориулалтаар 46°52'3.70"N 102°18'43.80"E, 46°52'5.80"N, 102°18'43.40"E, 46°52'6.70"N, 102°18'47.80"E, 46°52'4.60"N, 102°18'48.60"E байршилд газрыг түр хугацаагаар ашиглуулсугай.

2. Ашиглуулах газарт холбогдох материалыг бүрдүүлж, хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (И.Маралмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

My Doc zakhiramj /ZD/2023

— 1 22301145